

**ХАВСРАЛТ “Б”**

**ЗЭВСГИЙН ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ  
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРЖ БАЙГАА  
УЛСАД ЗОРИУЛСАН “WELCOME PACK”**

**ANNEX B**

**‘WELCOME PACK’ FOR NEW STATES PARTIES  
TO THE ARMS TRADE TREATY**

## ХАВСРАЛТ “Б”

### ЗЭВСГИЙН ХУДАЛДААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРЖ БАЙГАА УЛСАД ЗОРИУЛСАН “WELCOME PACK”

1. Удиртгал.....	3
1.1 “WELCOME PACK” нь хэнд зориулагдсан бэ?.....	3
1.2 Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ (ЗХЗГ) гэж юу вэ?.....	3
1.3 Батлагдсан ба хүчин төгөлдөр болсон нь.....	3
1.4 ЗХЗГ-нд хэдэн улс элссэн бэ?.....	4
1.5 ЗХЗГ-ний хамрах хүрээ юу вэ?.....	4
1.5.1 ЗХЗГ-нд ямар төрлийн зэвсгүүд хамрагддаг вэ?.....	4
1.5.2 ЗХЗГ-нд ямар төрлийн шилжилт хөдөлгөөн хамрагддаг вэ?.....	4
2. ЗХЗГ-ний үйл явц.....	5
2.1 Оролцогч улсуудын бага хурал.....	5
2.1.2 Хэзээ зохион байгуулагддаг вэ?.....	5
2.1.2 Ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?.....	5
2.1.3 Хэн оролцдог вэ?.....	5
2.2 Бэлтгэл ажил.....	6
2.2.1 Албан бус бэлтгэл уулзалт.....	6
2.2.2 Ээлжит бус уулзалт.....	6
2.3 ЗХЗГ-ний бүтэц бүрэлдэхүүн.....	6
2.3.1 Бага хурлын албан тушаалтнууд.....	7
2.3.1.1 Хурлын дарга.....	7
2.3.1.2 Хурлын дэд дарга.....	7
2.3.1.3 Хурлын нарийн бичгийн дарга.....	7
2.3.2 Туслах байгууллага.....	7
2.3.2.1 Удирдах хороо.....	8
2.3.2.2 Ажлын хэсгүүд.....	8
2.3.2.3 Хамтын сайн дурын сан сонгон шалгаруулах хороо.....	9
3. ЗХЗГ-ний үүрэг.....	9
3.1 Гэрээнд заасан зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хянах үүрэг гэж юу вэ?.....	9
3.1.1 Үндэсний хяналтын тогтолцоо.....	9
3.1.2 Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах.....	10
3.1.2.1 Тодорхой зарим тээвэрлэлтэд тавигдах хориг.....	10
3.1.2.2 Экспортлох.....	10
3.1.2.3 Импортлох.....	11
3.1.2.4 Дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэх.....	11

3.1.2.5 Зуучлах (Brokering).....	12
3.1.2.6 Зувчуулах (Diversion).....	12
4. Гэрээнд заасан тайлан боловсруулах үүрэг юу вэ?.....	12
4.1 Анхны тайлан.....	13
4.2 Жилийн тайлан.....	13
4.3 Зувчуулсан тухай тайлан.....	13
5. Гэрээнд заасан санхүүгийн үүрэг юу вэ?.....	14
5.1 Оролцогч улс.....	14
5.2 Гарын үсэг зурсан улс ба ажиглагч улс.....	14
6. ЗХЗГ-г хэрэгжүүлэхэд зориулсан туслалцаа, дэмжлэг.....	14
6.1 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар.....	14
6.1.1 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг юу вэ?.....	14
6.1.2 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газартай яаж холбоо барих вэ?.....	15
6.2 Ямар төрлийн санхүүгийн туслалцаа байх боломжтой вэ?.....	15
6.2.1 Хамтын сайн дурын сан (VTF).....	15
6.2.2 Спонсоршип программ.....	16
6.2.3 UNSCAR.....	16
6.2.4 Европын холбооны ЗХЗГ өргөжүүлэх төсөл.....	16
6.2.5 Хоёр тал хоорондын туслалцаа.....	17
6.3 Ямар хэлбэрийн техникийн дэмжлэгийг авч болох вэ?.....	17

## **1. Удиртгал**

### **1.1 “WELCOME PACK” нь хэнд зориулагдсан бэ?**

“WELCOME PACK”-ийг “Гэрээг түгээмэлжүүлэх ажлын хэсэг” (WGTU)-ээс боловсруулсан болно. “WELCOME PACK” нь гэрээний шинэ гишүүн улсууд ба гэрээний талаар илүү ихийг мэдэхийг сонирхож буй улсуудад Зэвсгийн худалдааг зохицуулах тухай олон улсын гэрээний явц болон үүргийн талаар үндсэн тойм өгөх зорилготой.

### **1.2 Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ гэж юу вэ?**

Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ (ЗХЗГ) нь олон улсын зэвсгийн наймаанд хамгийн дээд түвшний стандартыг тогтоосноор олон улсын зэвсгийн худалдааг зохицуулах, мөн зэвсгийн хууль бус наймаа хийх болон зувчуулахаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилготой олон улсын гэрээ юм.

Гэрээний 1-р зүйлд дараах зорилтууд тусгагдсан байна.

- Олон улсын зэвсгийн худалдааны эрх зүйг зохицуулах болон эрх зүйн зохицуулалтыг сайжруулахын тулд боломжтой хамгийн дээд түвшний нийтлэг стандартыг тогтоох
- Зэвсгийн хууль бус наймаа болон зувчуулалтаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох
- Олон улсын болон бүс нутгийн энх тайван, тогтвортой, аюулгүй байдалд хувь нэмрээ оруулах
- Хүн төрөлхтний зовлон зүдгүүрийг (human suffering) багасгах
- Олон улсын зэвсгийн худалдаанд оролцогч улсуудын хамтын ажиллагаа, ил тод байдал, хариуцлагатай үйлдлийг дэмжиж, улмаар оролцогч улс орнуудын дунд итгэлцлийг бий болгох

“Энэ нь дэлхийн зэвсгийн худалдаанд үүрэг, хариуцлага, ил тод байдлыг авчрах бидний хамтын хүчин чармайлтад шинэ хуудас нээж буйг илтгэн харуулж байна.” Бань Ги Мунь<sup>1</sup>

ЗХЗГ нь олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй ба тогтвортой байдалд хувь нэмэр оруулж, хүн төрөлхтний зовлон зүдгүүрийг багасгах ба хамтын ажиллагаа, ил тод байдал, хариуцлагатай үйл ажиллагааг дэмждэг.

### **1.3 Батлагдсан ба хүчин төгөлдөр болсон нь**

Энэхүү гэрээ нь НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2013 оны 4 дүгээр сарын 02 өдрийн тогтоолоор

---

<sup>1</sup> 2014 оны 12 дугаар сарын 23 өдөр. Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээ хүчин төгөлдөр болох тухай Ерөнхий нарийн бичгийн даргын хэлсэн үг.  
<<https://www.un.org/sg/en/content/sg/statement/2014-12-23/statement-secretary-general-entry-force-arms-trade-treaty>>

батлагдаж, 2014 оны 12 дугаар сарын 24 өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, дэлхий нийтийг хамарсан, зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах анхны хууль ёсны гэрээ юм.

#### **1.4 ЗХЗГ-нд хэдэн улс элссэн бэ?**

Одоогоор 100 гаруй улсууд “Гэрээнд оролцогч улс”-аар элссэн бөгөөд бусад нь уг гэрээнд гарын үсэг зурсан боловч хараахан батлаагүй байна.

ЗХЗГ-д оролцож буй байр суурь, бүс нутгийн тойм, шинэ мэдээллийг цаг тухайд нь дараах вэб сайтаас авах боломжтой.

<https://www.thearmstradetreaty.org/treaty-status.html?templateId=209883>

#### **1.5 ЗХЗГ-ний хамрах хүрээ юу вэ?**

ЗХЗГ нь тодорхой ангиллын зэвсгүүдийн тодорхой төрлийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулна.

##### **1.5.1 ЗХЗГ-нд ямар төрлийн зэвсгүүд хамрагддаг вэ?**

ЗХЗГ нь дараах ангиллын ердийн зэвсгүүдийн олон улсын арилжааг зохицуулна. (2.1-р зүйлийг харах):

- 1) Байлдааны танк
- 2) Байлдааны хуягт машин
- 3) Том калибрын артиллерын систем
- 4) Байлдааны нисэх онгоц
- 5) Дайрагч нисдэг тэрэг
- 6) Байлдааны хөлөг онгоц
- 7) Пуужин ба пуужин хөөргөх төхөөрөмж
- 8) Буудлагын зэвсэг болон хөнгөн зэвсэг

Түүнчлэн ЗХЗГ нь дээр дурдсан зэвсгүүдийн бууддаг, харвадаг, байнд хүргэдэг сум, галт хэрэгслийн экспорт болон дурдсан зэвсгүүдийг угсрах боломжийг бүрдүүлэх эд анги, бүрэлдэхүүн хэсгүүдийн экспортонд хамрана (3, 4-р зүйлийг харах).

##### **1.5.2 ЗХЗГ-нд ямар төрлийн шилжилт хөдөлгөөн хамрагддаг вэ?**

ЗХЗГ нь дараах төрлийн бүхий л арилжааг зохицуулна (2.2-р зүйлийг харах).

- экспортлох
- импортлох
- дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэх

- зуучлах

Энэхүү гэрээ нь тухайн оролцогч улс ердийн зэвсгийг өөрийн өмчлөл дор байлгана гэж үзсэн тохиолдолд, тухайн улс өөрөө ашиглах зорилгоор ердийн зэвсгийн тээвэрлэлтийг шууд гүйцэтгэж буй, эсвэл бусдаар гүйцэтгүүлж буй олон улсын тээвэрт үйлчлэхгүй (2.3-р зүйлийг харах).

ЗХЗГ нь улс орнуудын өөрийгөө хамгаалах эрхээ хэрэгжүүлэх болон энхийг сахиулах үйл ажиллагаанд зориулж ердийн зэвсэг худалдан авах хууль ёсны ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрдөг (ЗХЗГ-ний зарчим 7-р зүйлийг харах).

## **2. Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээний үйл явц**

### **2.1 Оролцогч улсын бага хурал**

#### 2.1.1 Хэзээ зохион байгуулагддаг вэ?

Гэрээний 17.1-р зүйлд заасны дагуу оролцогч улсын бага хурал бүр дараагийн хурлын товыг шийднэ. Үйл ажиллагааны дүрэмд бага хурлаар өөр шийдвэр гаргаагүй тохиолдолд бага хурал “жил бүр” хуралдана гэж тусгажээ. (Үйл ажиллагааны дүрмийн 11-р зүйлийг харах).

ЗХЗГ-ний оролцогч улсын бага хурал дараах товын дагуу зохион байгуулагдсан.

- ЗХЗГ-д оролцогч улсын I бага хурал (CSP 1): Канкун, Мексик, 2015 оны 8-р сарын 24-27
- ЗХЗГ-д оролцогч улсын II бага хурал (CSP 2): Женев, Швейцарь, 2016 оны 8-р сарын 22-26
- ЗХЗГ-д оролцогч улсын III бага хурал (CSP 3): Женев, Швейцарь, 2017 оны 9-р сарын 11-15
- ЗХЗГ-д оролцогч улсын IV бага хурал (CSP 4): Токио, Япон, 2018 оны 8-р сарын 20-24
- ЗХЗГ-д оролцогч улсын V бага хурал (CSP 5): Женев, Швейцарь, 2019 оны 8-р сарын 26-30

#### 2.1.2. Ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

Оролцогч улсын бага хурлын үүрэг нь:

- 1) Ердийн зэвсгийн салбарт гарч байгаа шинэчлэлийг оролцуулан энэхүү гэрээний хэрэгжилтийг дүгнэх
- 2) Энэхүү гэрээний хэрэгжилт болон үйл ажиллагаа, ялангуяа түгээмэлжүүлэхийг дэмжих талаарх зөвлөмжийг хэлэлцэх, батлах
- 3) 20 дугаар зүйлд заасны дагуу энэхүү гэрээний нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцэх
- 4) Энэхүү гэрээг тайлбарлахтай холбоотой үүссэн асуудлуудыг хэлэлцэх
- 5) Нарийн бичгийн дарга нарын газрын ажил үүрэг ба төсвийг хэлэлцэж шийдвэрлэх
- 6) Энэхүү гэрээний хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай туслах байгууллагуудыг үүсгэн байгуулах талаар судалж үзэх
- 7) Энэхүү гэрээнд нийцсэн бусад үйл ажиллагаа явуулах (17.4-р зүйлийг харах).

#### 2.1.3. Хэн оролцдог вэ?

Үйл ажиллагааны дүрэм нь оролцогч улсын хүсэлтийн дагуу бага хурлаас өөрөөр шийдвэрлээгүй бол оролцогч улсын нэгдсэн чуулганыг нээлттэй явуулахаар тусгасан (Үйл ажиллагааны дүрмийн 13-р зүйлийг харах). Үүний дагуу оролцогч улс, гарын үсэг зурсан улс, ажиглагч улс (гэрээнд нэгдээгүй, гарын үсэг зураагүй орнууд), Нэгдсэн үндэсний байгууллагын төлөөлөл ба түүний төрөлжсөн агентлагууд, олон улсын ба бүс нутгийн Засгийн газар хоорондын байгууллага, төрийн бус байгууллагыг хамарсан иргэний нийгэм, аж үйлдвэрийн төлөөлөл нь бүгд өөрөөр шийдвэрлээгүй бол, мөн өөрөөр шийдвэрлэх хүртэл оролцогч улсын бага хуралд оролцож болно (Үйл ажиллагааны дүрмийн 1.5-р зүйлийг харах).

Гэсэн хэдий ч зөвхөн оролцогч улс нь энэхүү бага хуралд “*бүрэн хэмжээгээр*” оролцож болно (өөрөөр хэлбэл, хурлын шийдвэр батлах, шаардлагатай тохиолдолд хурлын шийдвэртэй холбоотой санал хураалтад оролцох эрх нь зөвхөн оролцогч улсад байна гэсэн утгатай). Гарын үсэг зурсан улс орнууд бага хуралд оролцож болох боловч шийдвэр гаргахад оролцох боломжгүй. Ажиглагч орнууд ба НҮБ-ын төлөөлөл, олон улсын болон бүс нутгийн байгууллага, иргэний нийгэм, аж үйлдвэрүүдийн төлөөлөл нь бага хуралд ажиглагчаар оролцож, нэгдсэн чуулган дээр мэдэгдэл хийх, албан ёсны баримт бичиг хүлээн авах, санал бодлоо бага хуралд бичгээр ирүүлж болно.

## **2.2 Бэлтгэл ажил**

### **2.2.1 Албан бус бэлтгэл уулзалтууд**

Оролцогч улсын бага хурлын завсрын үеэр Женев дэх ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газраас дараагийн хуралд бэлтгэх зорилгоор албан бус бэлтгэл уулзалтуудыг зохион байгуулна. Албан бус бэлтгэл уулзалтын тоо, үргэлжлэх хугацааг тогтоогоогүй боловч ихэвчлэн оролцогч улсын бага хурлыг зохион байгуулахаас өмнө хоёр удаагийн албан бус бэлтгэл уулзалтыг нэг өдрийн хугацаатайгаар зохион байгуулдаг. Бэлтгэл уулзалтын тов нь ихэвчлэн ЗХЗГ-ний ажлын хэсгийн хуралдаантай давхцаж байхаар зохицуулагдсан байна (2.3.2.2-ийг харах). Бэлтгэл уулзалтууд нь гадаад дотоодод нээлттэй байдаг.

### **2.2.2 Ээлжит бус уулзалтууд (Extraordinary meetings)**

Гэрээний 17.5-р зүйлд зааснаар аль нэг оролцогч улсаас ээлжит бус уулзалтын талаар хүсэлт гаргаж, түүнийг бүх оролцогч улсын гуравны хоёр нь дэмжсэн тохиолдолд оролцогч улсын хурал хоорондын үеэр ээлжит бус уулзалтыг зохион байгуулж болно. Өөрөөр шийдвэрлээгүй бол, ээлжит бус уулзалтыг Женев дэх ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газраас зохион байгуулна (Үйл ажиллагааны дүрмийн 14-р зүйлийг харах).

### **2.3 ЗХЗГ-ний бүтэц бүрэлдэхүүн**

## 2.3.1 Бага хурлын албан тушаалтнууд

### 2.3.1.1. Хурлын дарга

Зэвсгийн худалдааг зохицуулах гэрээнд оролцогч улсууд бага хурлаасаа (CSP) дараа жилийн ээлжит бага хурал ба бэлтгэл ажлын явцыг удирдах бага хурлын даргыг сонгодог.

Жил бүрийн бага хурлын даргаар доорх хүмүүс ажиллаж байсан байна.

- CSP 1: Мексикийн элчин сайд Jorge Lomónaco
- CSP 2: Нигэрийн элчин сайд Emmanuel E. Imohe
- CSP 3: Финландын элчин сайд Klaus Korhonen
- CSP 4: Японы элчин сайд Nobushige Takamizawa
- CSP 5: Латвийн элчин сайд Jānis Kārklīš

### 2.3.1.2 Хурлын дэд дарга

Үйл ажиллагааны дүрмийн 9-р зүйлийн дагуу ЗХЗГ-ний оролцогч улсуудын бага хурал тус бүрээс дараагийн хурлын даргаар ажиллах 1 хүн, дэд даргаар ажиллах 4 хүнийг оролцогч улсуудын төлөөлөгч нарын дундаас сонгоно.

Хурлын 1 дарга ба 4 дэд дарга нарыг албан бусаар “Товчоо”(the Bureau) гэж нэрлэх бөгөөд энэхүү товчоо нь хурлын дарга ба дэд даргаар сонгогдсон тухайн хурал дууссан хугацаанаас эхлэн дараагийн ээлжит хурлын төгсгөлд шинэ хурлын дарга, дэд дарга сонгогдох хүртэл ажиллана.

Хурлын дарга (хурлын дэд дарга нарын дэмжлэгтэйгээр) нь бүрэн эрхийн хугацаандаа зохион байгуулагдах оролцогч улсын бага хурлын тусгай уулзалтуудыг удирдан зохион байгуулна.

### 2.3.1.3 Нарийн бичгийн дарга нарын газрын дарга

Үйл ажиллагааны дүрмийн 10-р зүйлийн дагуу ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын дарга нь оролцогч улсуудын бага хурал болон туслах байгууллагын бүхий хуралд нарийн бичгийн даргаар ажиллана. Нарийн бичгийн дарга нарын газрын дарга нь ээлжит болон ээлжит бус хурлуудтай холбоотой бүх бэлтгэлийг хийж, ерөнхийдөө гэрээний 18.3-р зүйлийн (г) заалтын дагуу оролцогч улсуудын бага хурлаас шаардах бусад бүх ажлуудыг хариуцан хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэнэ.

ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын чиг үүргийг 6.1.1-р зүйлд тайлбарласан болно.

## 2.3.2 Туслах байгууллага

Үйл ажиллагааны дүрмийн 42 нь гэрээний 17.4–р зүйлийн дагуу оролцогч улсын бага хурлаас туслах байгууллагыг байгуулж болно гэж заасан. Оролцогч улсын бага хурал нь гэрээний дагуу байгуулагдсан аливаа туслах байгууллагын бүрэн эрх, ажилтнууд, бүрэлдэхүүн, хэмжээ,



үргэлжлэх хугацаа, төсөвтэй холбогдох асуудлуудыг шийдвэрлэнэ.

ЗХЗГ-ний одоогийн туслах байгууллага нь:

- Удирдах хороо
- Гурван ажлын хэсэг:
  - Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хэсэг
  - Ил тод байдал ба тайлан боловсруулах ажлын хэсэг
  - Гэрээг түгээмэлжүүлэх ажлын хэсэг
- Хамтын сайн дурын сан (VTF)

Байгууллага тус бүрийн чиг үүргийг тайлбарлавал:

### 2.3.2.1 Удирдах хороо

ЗХЗГ-нд оролцогч улсын анхдугаар хурал нь гэрээний 17.4 –р зүйл ба үйл ажиллагааны дүрмийн 42-р зүйлийн дагуу Удирдах хороог туслах байгууллагын чиг үүрэгтэй байгуулсан. Удирдах хорооны үүрэг нь санхүүгийн асуудлууд ба ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газартай холбогдох бусад асуудлыг удирдан хяналт тавьж, хариуцлагатай, бүтээмжтэй, ил тод байдлыг дээд хэмжээнд байлгаж нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг дээд зэргээр бэхжүүлэхэд чиглэдэг.

Удирдах хороо нь оролцогч улсын бага хурлын дарга ба НҮБ-ын бүс нутаг хариуцсан хэсэг тус бүрээс томилогдсон оролцогч улсын төлөөлөгчөөс бүрддэг. ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын төлөөлөгч нь хуралд оролцдог. Гэрээнд гарын үсэг зурсан улсын төлөөлөгчийг зарим зохистой тохиолдолд Удирдах хорооны хуралдаанд ажиглагчаар оролцуулахаар урьж болно.

Удирдах хорооны гишүүд (ЗХЗГ-ний бага хурлын дарга болон төлөөллөөс бусад) хоёр жилийн хугацаанд ажиллах бөгөөд цаашид сунгагдан ажиллаж болно.

Удирдах хорооны үйл ажиллагаа нь Удирдах хорооны ажлын үндсэн чиг үүргийн (TOR) дагуу явагдана.

### 2.3.2.2 Ажлын хэсгүүд

Доорхи дурдах ажлын хэсгүүд 2016 оны оролцогч улсуудын 2 дугаар бага хурлын шийдвэрийн дагуу байгуулагдсан бөгөөд 2017 оны оролцогч улсуудын бага хурлын шийдвэрээр байнгын ажлын хэсгүүд болон ажиллах болсон.

- Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хэсэг (WGETI)
- Ил тод байдал ба тайлан боловсруулах ажлын хэсэг (WGTR)
- Гэрээг түгээмэлжүүлэх ажлын хэсэг (WGTU)

Оролцогч улсын бага хурлын дарга нь ажлын хэсэг тус бүрийн дарга нарыг томилох бөгөөд ажлын хэсэг бүрийн зорилго нь холбогдох ажлын үндсэн чиг үүргийн (TOR) дагуу дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулна.

“Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хэсэг” (WGETI) нь үндэсний хэмжээнд гэрээний бодит

хэрэгжилт ба үйл явцын тухай мэдээллийг хуваалцдаг. “Ил тод байдал ба тайлан боловсруулах ажлын хэсэг” (WGTR) нь ажлын хэсгийн нэр (өөрөөр хэлбэл, гэрээнд заасан ил тод байдал ба тайлан боловсруулах үүргийн тухай асуудал) –нд гарч байгаатай адил ерөнхийдөө оролцогч улсын бага хурлаас тодорхойлсон үүргийг гүйцэтгэдэг. “Гэрээ түгээмэлжүүлэх ажлын хэсэг” нь (WGTR) гэрээг түгээмэлжүүлэх тухай үзэл бодол, хэрэгжүүлэх арга барилыг бий болгож хуваалцана.

Ажлын хэсгүүдийн хуралдаан жилд дунджаар хоёр удаа, нийтдээ гурван өдөр үргэлжилдэг (оролцогч улсын бага хурлын албан бус бэлтгэл уулзалтуудын хугацаатай тохируулдаг, 2.2.1-ийг харх). Ажлын хэсэг тус бүр өөрсдийн үйл ажиллагааны явцын талаарх тайланг оролцогч улсын бага хуралд илгээдэг.

### *2.3.2.3 Хамтын сайн дурын сан (VTF) сонгон шалгаруулах хороо*

ЗХЗГ-ний оролцогч улсуудын 2 дугаар бага хурлаар жил бүрийн шаардлагын дагуу төслийн хүсэлтэнд боломжит санхүүжилтийг хуваарилахыг хамтын сайн дурын сан (ХСДС) удирдаж хянахаар болсон. Гэрээний 17.4-р зүйл, үйл ажиллагааны дүрмийн 42-р зүйлийн дагуу ХСДС сонгон шалгаруулах хороог туслах байгууллага болгон томилсон (6.2.1-р зүйлийг харх). Энэ хороо нь 15 хүртэлх гишүүн улсаас бүрдэж, 2 жилийн хугацаатайгаар томилогдон ажилладаг (цаашид дахин томилогдох боломжтой). ХСДС сонгон шалгаруулах хорооны үйл ажиллагааг ХСДС -ийн ажлын үндсэн чиг үүргээр (TOR) зохицуулна. ХСДС -ийн сонгон шалгаруулах хороо нь гишүүн улсын нэгийг даргаар сонгон томилох бөгөөд ХСДС -ийн сонгон шалгаруулах хорооны дарга нь оролцогч улсын бага хуралд ХСДС-ийн ажил байдлын талаар тайлагнадаг.

## **3. ЗХЗГ-ний үүрэг**

### **3.1 Гэрээнд заасан зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хянах үүрэг гэж юу вэ?**

#### **3.1.1 Үндэсний хяналтын тогтолцоо (National Control System)**

Гэрээний 5-р зүйлд заасан үндсэн үүрэг бол оролцогч улсууд ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийг экспортлох, импортлох, дамжин өнгөрөх ба дамжин тээвэрлэх, зуучлахыг зохицуулах үндэсний хяналтын тогтолцоог бий болгож, тогтвортой ажиллагааг хангах ёстой.

Үндэсний хяналтын тогтолцооны нэг хэсэг нь оролцогч улс бүр өөрийн хяналтын тогтолцоонд хамрагдсан зэр зэвсэг, эд зүйлсийн улсын хяналтын жагсаалтыг боловсруулж, хадгалах шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн улсын тээвэрлэлтийг хянах, зохицуулах жагсаалт юм. Оролцогч улсууд үндэсний хяналтын жагсаалтаа ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газарт ирүүлж, нарийн бичгийн дарга нарын газар нь үүнийг бусад оролцогч улсуудад ашиглагдахаар болгоно. Оролцогч улсууд өөрийн улсын үндэсний хяналтын жагсаалтыг гадаад оруудад нээлттэй болгох

үйл ажиллагааг дэмжинэ.

Оролцогч улс бүр үр дүнтэй, ил тод үндэсний хяналтын тогтолцоотой болохын тулд нэгээс дээш эрх бүхий үндэсний байгууллагыг томилох ёстой ба тэд гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл солилцох зорилгоор мөн нэгээс дээш холбоо барих байгууллагыг тогтооно.

“Гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын хэсэг” нь гэрээний шаардлагын дагуу үндэсний хяналтын тогтолцоог хэрхэн бий болгох талаар нарийвчилсан зөвлөмжийг агуулсан “Үндэсний хяналтын тогтолцоог бий болгох үндсэн гарын авлага” (Voluntary Basic Guide to Establishing a National Control System)-ыг боловсруулсан.

Оролцогч улсын 4 дүгээр бага хурлын тайлан (ATT/CSP4.WGETI/2018/CHAIR/355/Conf.Rep) Хавсралт А. Оролцогч улс гэрээний 5-р зүйлийг хэрэгжүүлэх, харилцан хэлэлцэхэд “Гэрээний 5-р зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдох оролцогч улсууд ашиглах боломжтой лавлах баримт бичгийн жагсаалт” нь мэдээллийн эх үүсвэр ба удирдамж болж байна.

### 3.1.2 Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

#### 3.1.2.1 Тодорхой зарим тээвэрлэлтэд тавигдах хориг

“Шилжилт хөдөлгөөн” (transfer) гэдгийг гэрээний 2.2-р зүйлд экспортлох, импортлох, дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэх, зуучлах үйлчилгээнээс бүрдэнэ гэж тодорхойлсон.

Гэрээний 6-р зүйлд заасны дагуу оролцогч улсууд дараах нөхцөлд ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн шилжилт хөдөлгөөнд зөвшөөрөл өгөхийг хориглоно.

- Тухайн шилжилт хөдөлгөөн нь “НҮБ-ын үндсэн дүрэм”-ийн 7-р бүлэгт заасан НҮБ-ийн Аюулгүй байдлын зөвлөлийн гаргасан зэвсгийн хоригийг зөрчсөн тохиолдолд
- Тухайн шилжилт хөдөлгөөн нь тухайн улсын элсэн орсон олон улсын гэрээний холбогдох үүргийг зөрчих нөхцөл үүсэх магадлалтай тохиолдолд
- Тухайн зэвсэг болон эд зүйл нь хоморголон устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг эсвэл дайны гэмт хэрэг үйлдэхэд ашиглагдахыг оролцогч улс "зөвшөөрөл өгөх үед мэдсэн" тохиолдолд

Хэрэв тухайн шилжилт хөдөлгөөн 6-р зүйлд заасны дагуу хориглогдоогүй бол оролцогч улс гэрээний бусад заалтын дагуу шилжилт хөдөлгөөнийг зохицуулах ёстой (дараах зүйлийг харах).

Оролцогч улсын 4 дүгээр бага хурлын тайлан (ATT/CSP4.WGETI/2018/CHAIR/355/Conf.Rep) Хавсралт Е. Оролцогч улс гэрээний 6.1-р зүйлийг хэрэгжүүлэхэд “Гэрээний 6.1-р зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой сайн дурын удирдамж, дэмжлэг” нь үндсэн чиглэл болно.

#### 3.1.2.2 Экспортлох

Гэрээний 7-р зүйлд зааснаар хэрэв шилжилт хөдөлгөөн нь ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн экспортод хамааралтай бол экспортлогч улс нь тухайн зэвсэг, эд зүйлс нь энх тайван, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх болон аюулгүй

байдлыг бууруулах эсэхийг, мөн доор дурдсан байдлаар ашиглагдах эсэх эрсдэлийг үнэлэх шаардлагатай.

- ☞ олон улсын хүмүүнлэгийн хуулийг ноцтой зөрчих
- ☞ олон улсын хүний эрхийн тухай хуулийг ноцтой зөрчих
- ☞ терроризмтой холбогдох олон улсын гэрээн дэх гэмт хэргийг бүрэлдэхүүнтэй үйлдэл
- ☞ үндэстэн дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй холбогдох олон улсын гэрээн дэх гэмт хэргийг бүрэлдэхүүнтэй үйлдэл

Экспорт хийж байгаа байгаа гэрээнд оролцогч улс нь тодорхой мэдэгдэж буй эрсдлийг бууруулахын тулд итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ, экспортлогч ба импортлогч улсын хамтран боловсруулж баталсан хөтөлбөр гэх мэт арга хэмжээ байгаа эсэхийг бодолцож үзэх хэрэгтэй.

Экспортлогч улс нь гэрээний 7.1-р зүйлд дурдсанаар ямар нэг сөрөг үр дагаврууд үүсэх “ноцтой (overriding) эрсдэл” байгаа гэж үзвэл уг экспортыг зөвшөөрч болохгүй.

Экспортлогч улс нь ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийг хүйсийн тэгш эрхэд халдсан хүчирхийлэл, эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн эсрэг ноцтой хүчирхийлэл үйлдэх болон дэмжихэд ашиглагдах эрсдэлийг харгалзан үзэж (7.4-р зүйлийг харах) тухайн экспортыг зувчуулах эрсдэлийг үнэлэх хэрэгтэй (11-р зүйлийг харах).

Оролцогч улсуудын 4-р бага хурлын тайлан (ATT/CSP4.WGETI/2018/CHAIR/355/Conf.Rep Хавсралт Б. Гэрээний 7-р зүйлийг хэрэгжүүлж, харилцах хэлэлцэхэд “7-р зүйлд заасан эрсдлийн үнэлгээ хийхэд оролцогч улсууд ашиглах боломжтой лавлах баримт бичгийн жагсаалт” нь мэдээллийн эх үүсвэрийн талаарх заавар болж байна.

### *3.1.2.3 Импортлох*

Гэрээний 6-р зүйлд зааснаар ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн зарим тодорхой импортыг хориглосонтой холбогдуулан (дээр дурдсан 3.1.2.1-ийг харах), зэвсэг импортлох буй оролцогч улс бүр “ердийн зэвсгийн импортыг шаардлагатай тохиолдолд хуулиар зохицуулах арга хэмжээ” авах ёстой.

ЗХЗГ нь үндэсний хяналтын тогтолцоонд импортыг зохицуулахдаа ямар арга хэмжээ авахыг тодорхой заагаагүй ч, зэвсэг импортлохдоо холбогдох улсаас лиценз болон зөвшөөрөл хэлбэрийн баталгааг авах хэрэгтэй гэсэн шаардлага, мөн эцсийн хэрэглэгч болон гаалийн шалган нэвтрүүлсэн гэрчилгээ авах хэрэгтэй гэсэн шаардлага багтана.

Импортлогч улс нь экспортлогч улсын зүгээс эрсдлийн үнэлгээг хэрэгжүүлэх зорилго бүхий холбогдох мэдээллийг гаргаж өгөхийг хүссэн тохиолдолд, экспортлогч улсыг мэдээллээр хангаснаа баталгаажуулахад чиглэх арга хэмжээ авах шаардлагатай гэж энэхүү гэрээнд заасан бөгөөд уг арга хэмжээнд эцсийн хэрэглээ, эцсийн хэрэглэгчид холбогдох бичиг баримтжуулалт багтсан байж болно.

### *3.1.2.4 Дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэх*

Гэрээний 6-р зүйлд (дээр дурдсан 3.1.2.1-ийг харах) зааснаар тусгай нөхцөл байдалд ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсгийн дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэлтээс гадна, гэрээний 9-р зүйл нь оролцогч улсуудыг "шаардлагатай болон боломжтой тохиолдолд" мөн "холбогдох олон улсын хууль тогтоомжтой нийцүүлэн" дотоод журмаараа ердийн зэвсгийг дамжин өнгөрөх, дамжуулан тээвэрлэх асуудлыг зохицуулахын тулд зохих арга хэмжээ авахыг шаардана.

Үндэсний хяналтын тогтолцооны нэг хэсэг болох дамжин өнгөрөх, дамжуулан тээвэрлэхийг журамлахын тулд авах арга хэмжээ нь юу болохыг ЗХЗГ-нд заагаагүй. Гэсэн ч дамжин өнгөрөх дамжуулан тээвэрлэхийн тулд тусгай лиценз болон зөвшөөрлийн хэлбэрээр холбогдох оролцогч улсаас зөвшөөрөл авах хэрэгтэй гэсэн шаардлага/мөн тээвэрлэлтийг гүйцэтгэгч нь зэвсэг тухайн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрнө гэдгийг дамжин тээвэрлэх улсад урьдчилан мэдэгдэх хэрэгтэй гэсэн шаардлага багтдаг.

#### **3.1.2.5 Зуучлах (Brokering)**

Гэрээний 6 дугаар зүйлд (дээр дурдсан 3.1.2.1-ийг харах) заасны дагуу тодорхой нөхцөл байдалд ердийн зэвсэг, галт хэрэгсэл/ зэр зэвсэг, түүний эд анги болон бүрэлдэхүүн хэсэг дамжин өнгөрөх, дамжин тээвэрлэхээс гадна, гэрээний 10 дугаар зүйлд оролцогч улс бүр ердийн зэвсгийн зуучлалын тухайд "өөрийн улсын хариуцлаган доор хийгдэх зуучлалыг журамлах арга хэмжээ авахдаа дотоодын хууль тогтоомжид нийцүүлэх ёстой" гэж заасан. Энэхүү гэрээ нь эдгээр арга хэмжээ нь зуучлал хийхийн өмнө зуучлагч нар холбогдох зуучлалыг бүртгүүлэх болон бичгээр хийсэн зөвшөөрөл гаргуулахыг шаардаж байгааг багтааж болохыг тусгасан байна.

#### **3.1.2.6 Зувчуулах**

ЗХЗГ-ний 11-р зүйлд ердийн зэвсгийг зувчуулахаас урьдчилан сэргийлэх, шалгах, ойлголтыг дээшлүүлэхийг зорьсон олон амлалтыг багтааж байна. Экспортлогч орнууд экспортыг зувчуулах эрсдлийн үнэлгээ хийж, итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ болон экспортлогч болон импортлогч орнууд хамтран хөгжүүлж, зөвшилцсон хөтөлбөр зэрэг эрсдлийг бууруулах арга хэмжээ бий болгох талаар бодолцох ёстой.

Мөн түүнчлэн, 11-р зүйлд заасны дагуу шилжилт хөдөлгөөний үйл явцад оролцож буй улс бүр зэвсэг зувчуулахыг хянаж, урьдчилан сэргийлэх үүрэгтэй. ЗХЗГ нь оролцогч улсууд сум хэрэгсэл, эд ангиуд зувчуулахыг хянаж урьдчилан сэргийлэхийг шаарддаггүй боловч оролцогч улсууд үүнийг өөрсдөө сонгон хэрэгжүүлж болно.

Шилжилт хөдөлгөөнд оролцож буй улс орон хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох нь энэхүү заалтын нэг чухал хэсэг бөгөөд нэг улсын хүчин чармайлтаар ердийн зэвсэг зувчуулахыг хянах нь боломжгүй байгаа бодит байдлыг онцолж байна.

#### **4. Гэрээнд заасан тайлан боловсруулах үүрэг юу вэ?**

#### **4.1 Анхны тайлан**

ЗХЗГ-ний 13.1-р зүйлд заасны дагуу, оролцогч улсууд нь “үндэсний хууль тогтоомж, үндэсний хяналтын жагсаалт болон бусад зохицуулалт, захиргааны арга хэмжээг оролцуулан” гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний анхны тайланг ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газарт гаргаж өгөх “шаардлага” байдаг. Мөн гэрээг хэрэгжүүлэхийн тулд тухайн холбогдох улс хэрэгжүүлсэн бүхий л шинэ арга хэмжээгээ нарийн бичгийн дарга нарын газарт тайлагнах хэрэгтэй.

Оролцогч улс бүр “гэрээ тухайн оролцогч улсад хүчин төгөлдөр болсноос 1 жилийн дотор” анхны тайланг гаргаж өгөх шаардлагатай. Иймээс, оролцогч улсын анхны тайланг гаргаж өгөх эцсийн хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 12 сарын дараа дуусна<sup>2</sup>.

Оролцогч улсуудад анхны тайлангаа бэлтгэхэд туслах зорилгоор тайлангийн загвар боловсруулсан бөгөөд анхны тайланг ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газарт онлайнээр ирүүлж болно.

#### **4.2 Жилийн тайлан**

ЗХЗГ-ний 13.3-р зүйлд заасны дагуу оролцогч улсууд өмнөх жилийн хугацаанд хийгдсэн (1 дүгээр сарын 01 өдрөөс 12 дугаар сарын 31 өдөр хүртэл) гэрээний 2.1-р зүйлд заасан ердийн зэвсгийн экспорт, импортын зөвшөөрөл, мөн бодит экспорт, импортын талаарх тайланг жил бүр гаргаж өгөх “шаардлага” байдаг.

Жилийн тайланг ЗХЗГ-ний хэрэг эрхлэх газарт хүргүүлэх эцсийн хугацаа нь жил бүрийн 5 дугаар сарын 31 өдөр юм. Тухайлбал, 2018 оны 1 дүгээр сарын 1 өдрөөс 12 дугаар сарын 31 өдөр хүртлэх экспорт, импортын талаарх 2018 оны жилийн эцсийн тайланг 2019 оны 5 дугаар сарын 31 өдрөөс өмнө өгсөн байна.

Оролцогч улсууд жилийн тайлангаа бэлтгэхэд туслах зорилгоор тайлангийн загвар боловсруулсан бөгөөд жилийн тайланг ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газарт онлайнээр ирүүлж болно.

#### **4.3 Зувчуулсан тухай тайлан**

Гэрээний 11.6-р зүйл ба 13.2-р зүйлд зааснаар, оролцогч улсууд зэвсэг зувчуулахыг хянахын тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайлагнахыг дэмждэг. Одоогоор зувчуулахыг таслан зогсооход авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухайд албан ёсны тайлангийн механизм байхгүй (тухайлбал, ийм тайланг бэлтгэх загвар байхгүй) учир оролцогч улсууд зувчуулсан тухай

---

<sup>2</sup> 2014 оны 12 дугаар сарын 24 өдрөөс хойш гэрээг хүлээн зөвшөөрч, баталж, гарын үсэг зурсан болон нэгдэн орсон улсын хувьд, холбогдох улсын гэрээ нь 22-р зүйлд заасны дагуу гэрээг батлах, хүлээн зөвшөөрөх, гарын үсэг зурах, нэгдэн орсон тухай баримт бичгээ ирүүлснээс хойш 90 дэх өдрөөс эхлэн энэхүү гэрээ хүчин төгөлдөр болно. Анхны тайланг хүлээн авах эцсийн хугацаа нь тухайн өдрөөс хойш арван хоёр сарын дараа байна.

мэдээллийг дурын загвараар боловсруулан явуулж болохоос гадна ЗХЗГ-ний вэб сайтад байрлах мэдээллийн платформыг ашиглан мэдээллийг солилцож, туршлагаа хуваалцаж болно.

## **5. Гэрээнд заасан санхүүгийн үүрэг юу вэ?**

### **5.1 Оролцогч улс**

Оролцогч улс нь хураамж төлөх бөгөөд төлөх хураамж нь дараах 2 төрөл байна.

1. Оролцогч улсын бага хурал ба тус бага хурлаар үүсгэх бүх туслах байгууллагуудад зориулсан хураамж: Бүх оролцогч улсууд нь бага хурал бусад хуралдаан, уулзалтанд оролцсон эсэхээс үл хамааран бага хуралд тус бүр, мөн оролцогч улсуудын бага хурлаас байгуулах бүх туслах байгууллагуудад хураамж төлөх бөгөөд үүнд оролцогч улсын бага хурал, туслах байгууллагын хурлын бэлтгэл, хурал зохион байгуулах зардлын хураамж багтана (ЗХЗГ-ний санхүүгийн дүрмийн 5.1-р зүйлийг харах).
2. Нарийн бичгийн дарга нарын газарт зориулсан хураамж: ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардал нь ажилчдын цалин, тоног төхөөрөмж, ажлын байр, санхүүгийн удирдлага, хүний нөөцийн удирдлага, даатгал, харилцаа холбоо, мэдээллийн технологи болон бага хурлаар шийдвэрлэсэн нарийн бичгийн дарга нарын газрын үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад зүйлсээс бүрдэх бөгөөд, оролцогч улсууд жил бүр эдгээр зардалд холбогдох хураамжийг төлнө (ЗХЗГ-ний санхүүгийн дүрмийн 6.3-р зүйлийг харах).

### **5.2 Гарын үсэг зурсан улсууд ба ажиглагч улсууд**

Оролцогч улсын бага хурал тус бүр болон оролцогч улсын бага хурлаас байгуулах туслах байгууллагуудын хуралд оролцож буй гарын үсэг зурсан улсууд ба бусад ажиглагч улсууд нь бага хурал, шаардлагатай тохиолдолд туслах байгууллагын хурлыг бэлтгэх, зохион байгуулах зардалд зориулсан оролцогчийн хураамж төлнө.

Оролцогч улсуудын бага хурлын төсөвтэй холбогдон гарах нэхэмжлэл нь тухайн жилд хуралд оролцсон бүх гарын үсэг зурсан улс болон бусад ажиглагч улсыг дараагийн ээлжит бага хуралд оролцоно гэсэн тооцоон дээр үндэслэн бодогддог .

## **6. ЗХЗГ-г хэрэгжүүлэхэд зориулсан туслалцаа, дэмжлэг**

### **6.1 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар**

#### **6.1.1 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газрын үүрэг юу вэ?**

ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь ЗХЗГ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор гэрээний 18-р зүйлд заасны дагуу байгуулагдсан болно.

ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь гэрээний дагуу тайлангийн үйл явцыг зохион байгуулах, улс орнуудын холбоо барих газрын мэдээллийн санг хариуцах, оролцогч улсын бага хурлын ажил үүргийг дэмжих, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор тусламж хүссэн болон үзүүлэх саналыг хүлээн авч зохицуулах, оролцогч улсын бага хурлаар шийдвэрлэсэн бусад ажлуудыг гүйцэтгэдэг. Оролцогч улсын бага хурлын ажил үүргийг дэмжих гэдэгт бага хурал тус бүрийн бэлтгэл шатанд хурлын дарга, дэд дарга, удирдах хороо, бага хурлаас байгуулсан ажлын хэсгийн дарга нарын ажил үүргийг дэмжих зэрэг багтана.

Үүний дээр гэрээний 18-р зүйлийн 3-т заасан уламжлалт хариуцлагаас гадна, ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь ХСДС сонгон шалгаруулах хороо болон ЗХЗГ-г дэмжих хөтөлбөрийн тусламжийг авч хамтын сайн дурын санг мөн удирдах болно.

#### 6.1.2 ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газартай холбоо барих арга

Хаяг: 7bis avenue de la Paix, WMO Building, 2nd floor, 1211 Geneva

Утас: +41 (0)22 715 04 20

Имэйл: [info@thearmstradetreaty.org](mailto:info@thearmstradetreaty.org)

Веб: [www.thearmstradetreaty.org](http://www.thearmstradetreaty.org)

#### 6.2 Ямар төрлийн санхүүгийн туслалцаа байх боломжтой вэ?

##### 6.2.1 Хамтын сайн дурын сан

ЗХЗГ-ний 16.3-р зүйл нь гэрээний дотоодын хэрэгжүүлэлтийг дэмжихийн тулд Хамтын сайн дурын сан(ХСДС) байгуулахаар зохицуулсан бөгөөд бүх оролцогч улс сангийн санхүүжилтэд хувь нэмэр оруулахыг сайшаадаг.

ХСДС нь зөвшөөрөгдсөн итгэлцлэлийн зүйлсийн дагуу ажиллуулахаар оролцогч улсын 2 дугаар бага хурлаар 2016 оны 8 дугаар сард албан ёсоор байгуулагдсан. ХСДС нь итгэмжлэлийн зүйлс болон удирдлагын дүрмийн дагуу ЗХЗГ хэрэгжүүлэх төсөлд хөрөнгө олгоно.

ХСДС нь ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь ХСДС-ийн сонгон шалгаруулах хорооны дэмжлэгтэйгээр удирдана(2.3 зүйлийг үзэх). ЗХЗГ-г хэрэгжүүлэх төслийн хувьд дээд тал нь 100 мянган доллар (ам доллар)-ын тусламжийг хүсч болох саналын хүсэлтийг жил бүр гаргах ба, гагцхүү улс л тусламжийн хүсэлт гаргаж болно.

ЗХЗГ вебсайт(<https://www.thearmstradetreaty.org/voluntary.htm>) -аар зочилбол илүү их мэдээлэл үзэх болно.



## 6.2.2 Спонсоршип хөтөлбөр

ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь улс орнуудын ЗХЗГ хуралд оролцохыг идэвхжүүлэх спонсоршип хөтөлбөрийг эрхлэн явуулна. ЗХЗГ-ний спонсоршип хөтөлбөрийн гол зорилго нь хурлын хугацаанд төлөөлөх үр дүн болон санал шийдвэрлэх явц дахь оролцоог баталгаажуулахын тулд ЗХЗГ-ний хуралд оролцох хэмжээ болон олон талт байдлыг нэмэгдүүлж, эцсийн дүндээ гэрээний хэрэгжилт болон түгээмэлжүүлэлтийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм. ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь ЗХЗГ-ний хурал тус бүрийн өмнө ЗХЗГ-ний имэйл хүлээн авагчийн жагсаалтад байгаа бүх хүмүүст хүсэлтийн хуудсыг хавсаргаж ЗХЗГ-ний вебсайтад мэдээллийг тавьснаар дэмжлэгийн хүсэлт гаргахыг албан ёсоор хүснэ.

## 6.2.3 UNSCAR

НҮБ-ын зэвсгийн зохицуулалтын хамтын ажиллагааны дэмжлэг (UNSCAR) нь зэвсгийн зохилцуулалтыг дэмжихийн тулд НҮБ-аас удирддаг сан бөгөөд ЗХЗГ-г оролцуулсан зэвсгийн зохицуулалттай холбоотой олон улсын байгууллагын шийдвэр / оролцоо мөн хэрэгжүүлэлтийг дэмждэг уян хатан чанартай олон талт итгэлцлийн байгууллага юм.

UNSCAR бол жил бүр санал болгох хүсэлтийг хэвлэн гаргаж НҮБ-ын түнш, олон улсын / бүс нутгийн байгууллаг, ТББ, судалгааны хүрээлэн зэргээс хүсэлт хүлээж авдаг. Дэмжлэг авахыг хүссэн засгийн газар нь шалгуур хангасан хүсэлт гаргагчтай хамтарч ажиллах ёстой.

Вебсайт (<https://www.un.org/disarmament/unscar/>)-аар зочилбол илүү их мэдээллэл авах болно.

## 6.2.4 EU ATT өргөжүүлэх төсөл

Европын холбоо нь “ЕХ-ны ЗХЗГ-г өргөжүүлэх төсөл”-ийг байгуулж, ЗХЗГ-ний хэрэгжилтэд зориулсан дэмжих хөрөнгийг оруулсан. Төсөл нь доорхитой адил олон төрлийн үйл ажиллагааг эрхэлдэг.

- Тухайн улсад тохирсон үйл ажиллагаагаар дамжуулан улс тус бүрт нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай зүйлсийг нягтлан үзэхийн тулд урт хугацааны түншлэлээр хангаж чадах тохиромжит хэлбэрийн үндэсний дэмжлэгийн хөтөлбөр
- Тухайлсан дэмжлэгийн хүсэлтэд уян хатан, шуурхай хандах боломжтой байх түр хугацааны тусгай үйл ажиллагаа
- Шилдэг туршлагыг хуваалцаж иргэний нийгмийн оролцогчийг оролцуулах ба бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхижүүлдэг платформоор хангах бүс нутгийн семинар

Тухайн улсын шууд хүсэлтийн дагуу холбогдох төсөлд дэмжлэг үзүүлнэ. Вебсайт ([https://export-control.jrc.ec.europa.eu/projects/arms-trade-treaty\)-aap](https://export-control.jrc.ec.europa.eu/projects/arms-trade-treaty)-aap) зочилбол илүү их мэдээллэл авах болно.

#### 6.2.5. Хоёр тал хоорондын туслалцаа

Хоёр тал хоорондын туслалцааны хэлбэрт суурилан ЗХЗГ-г хэрэгжүүлэхэд зориулсан санхүү, техникийн туслалцааг үзүүлдэг хандивлагч орнууд их байдаг. Иймэрхүү туслалцаа авахыг хүсч буй орнууд нь хандивлагч улстай шууд холбогдох хэрэгтэй.

### 6.3. Ямар хэлбэрийн техникийн дэмжлэгийг авч болох вэ?

Улс орон тухайн гэрээг хэрэгжүүлэхийн тулд өмнөх оролцогч улсуудаас техникийн талтай холбогдсон дэмжлэг хүсч болно. Олон улсын байгууллага, бүс нутгийн байгууллага, НҮБ-ын харьяа байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон ЗХЗГ-ний хэрэгжилттэй холбоотой судалгааны байгууллагууд олон байдаг бөгөөд ЗХЗГ-г хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрөл бүрийн техникийн дэмжлэг үзүүлж болно. ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар нь хэнд хэрхэн хандаж болох талаар зөвлөмж үзүүлэх боломжтой.

Үүнээс гадна, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, судалгааны байгууллагууд аас олон тооны практик зөвлөмж, судалгааны ажлууд, эдгээрээс бусад арга хэрэгсэлүүдийг хөгжүүлж ирсэн бөгөөд ЗХЗГ-ний ажлын хэсэгтэй хамт гэрээг хэрэгжүүлэх аргын талаарх техникийн зөвлөмж, зааварчилгааг үзүүлдэг.

#### *[Ар талын нүүр]*

Нөөц, хэрэгсэл, зааварчилгаа гэх мэтийг багтаасан гэрээний талаархи илүү дэлгэрэнгүй мэдээлэл ЗХЗГ-ний вебсайт Вебсайт (<https://www.thearmstradetreaty.org/>)-аас авч ашиглах боломжтой ба ЗХЗГ-ний нарийн бичгийн дарга нарын газар([info@thearmstradetreaty.org](mailto:info@thearmstradetreaty.org))-аас авч болно.